

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
2023 ОНЫ 2 САРЫН ТАЙЛАН, МЭДЭЭ**

2023.02.20

Чойр

Хугацаа: 2023.01.23-2023.02.20

Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Төрийн албаны тухай хууль, салбарын бусад хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийг мөрдөж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Хүний нөөц, дотоод ажлын хүрээнд:

Байгууллагын шуурхай хурлыг 1 удаа зохион байгуулж, өнгөрсөн 14 хоногийн үйл ажиллагааг хэлэлцэх, ажил эрчимжүүлэх, цаг үеийн мэдээллээр хангах, үйл ажиллагаатай холбоотой үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна. Албан хаагч бүрийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх, үүрэг даалгаврын биелэлтийн гүйцэтгэлийг сайжруулах хүрээнд үүрэг даалгаврын дэвтрийг албан хаагч бүрээр хөтөлж сарын тайланд үр дүнг нэгтгэж байна.

Удирдах ажилтны шуурхай хуралд 3 удаа оролцож, үүрэг даалгаврын биелэлтийг 3 удаа хүргүүлсэн.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд /ERP/ байгууллагын албан хаагчдыг бүрэн бүртгэж, ирсэн болон явуулсан бичиг бүртгэх, үүрэг даалгавар, мэдээлэл солилцох, өргөдөл гомдол шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаанд өдөр тутам ашиглаж байна.

2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнүүдийг газрын даргаар батлуулсан.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зацуулах, тайлагнах журам-ын 1.2 дахь заалтыг үндэслэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын 2023 оны төлөвлөгөөг Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд маягтын дагуу Сүмбэр, Баянтал, Шивээговь сумд болон аймгийн хэмжээнд бүрэн оруулж, сумдад зөвлөмж өгсөн.

Санхүүгийн үйл ажиллагаа: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 1 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад тайлан мэдээ, холбогдох гэрээ, тушаал бүхий мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан.

Байгууллагын даргын 2023 оны А/3 дугаар тушаалаар байгууллагын харьяалалтай 4 ахмадад хүндэтгэл үзүүлж, тус арга хэмжээний зардалд 480000 төгрөг зарцуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлт: Байгууллагад тус хугацаанд ирсэн албан бичиг 12, хариутай бичиг 5, хариутай бичгийн шийдвэрлэлт 100 хувь. Явуулсан албан бичиг 15, эргэж ирэх харуутай бичиг 2. Ирсэн, явуулсан бичгийг скайнердан программд оруулан ажиллаж байна. Өргөдөл, гомдол ирээгүй.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналтын хүрээнд:

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.


Авлигын эсрэг үйл ажиллагаа: Жил бүрийн 2 сарын 15-ны дотор төрийн албан хаагчид ХАСХОМ-ийг цахимаар авч хянан баталгаажуулсан. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2022 оны ХАСХОМ 1, ХАСХОМ 2, ХАСХОМ 3, ХАСХОМ 4 тайлангуудыг гаргаж хавсралтаар хүргүүлэв.

Мэдээлэл, сургалт, сурталчилгаа: Байгууллагын ил тод байдлыг хангах хүрээнд байгууллагын facebook болон цахим хуудсанд 12 мэдээлэл байршуулсан.

Хүрээлэн буй орчны бохирдол, газрын асуудлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/341 дугаар захирамжийн дагуу 6 аж ахуйн нэгж байгууллагад Агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийж, Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан (www.envpol.mne.gov.mn)-д шивж бүртгэлжүүлсэн. Мөн Сүмбэр сумын 2 дугаар багийн айл өрхийн эх үүсвэрийн тооллого, судалгааг программд шүүж тулган, нэмж бүртгэн Цаг уур, орчны шинжилгээний төвд мэдээг хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд мөрдөгдөх Агаар, орчны бохирдолтой холбоотой гарсан шийдвэрүүдээр цахим гарын авлага бэлтгэн Говьсүмбэр Байгаль орчин цахим хаягаар дамжуулан иргэд олон нийтэд ил тод байршуулсан.



Хоггүй цэвэрхэн шинэлцгээе уриалга бүхий гарын авлага, постер бэлтгэн Говьсүмбэр байгаль орчин цахим хаягаар дамжуулан олон нийтэд түгээсэн. Мөн бэлтгэсэн 30ш гарын авлагыг Шивээговь сумын Байгаль хамгаалагч Ганбаатарт хүргүүлсэн.



Ногоон байгууламж нэмэгдүүлэх чиглэлээр:

"JCI ОЮУНЫ ЭЛЧ-MIND UPDATE" Ногоон ирээдүй төслийн танилцуулга мэдээллийг нь 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Говьсүмбэр аймгийн Боржигин чуулгат амжилттай зохион байгуулсан.

Үйл ажиллагааны үеэр JCI ИХ ХҮРЭЭ САЛБАР БАЙГУУЛЛАГА-ын удирдлага, гишүүд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ нартай уулзаж, тус байгууллагын үүсэл хөгжил, байгаль орчны бүтээн байгуулалт, хамтын ажиллагааны талаар харилцан ярилцав.

Уулзалтаар Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар, ЖЭЙ СИ АЙ ИХ хүрээ салбар байгууллага хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурлаа.

Санамж бичигт 21 аймагт сурагчдыг ногоон иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор "Ногоон ирээдүй" сэдэвт сургалт зохион байгуулах, 21 аймагт тус бүр 1000 ширхэг мод тарихад хамтран ажиллах зорилгоор байгуулав.




Соёлын яам болон "JCI Монгол" төрийн бус байгууллагын JCI Их Хүрээ салбар байгууллагын малгай төслүүдийн нэг MIND UPDATE "Их хүрээ" салбараас Говьсүмбэр аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн -200 гаруй сурагчдад зориулан "ОЮУНЫ ЭЛЧ-MIND UPDATE" хувь хүний хөгжил, ногоон ирээдүй лекц, сургалтыг зохион байгуулав.

Тус сургалтыг нээж аймгийн Засаг даргийн орлогч Г.Наранбаатар үг хэлж, мод тарих үр өгөөжийн талаар ЕБС-ын сурагчдад мэдээлэл өгсөн.



MIND UPDATE сургалтад:

1. Ногоон ирээдүй
2. Мэргэжилдээ хэрхэн эзэн болох вэ?
3. Сэтгэлгээний өөрчлөлт
4. Хайрын 5 хэл
5. Тэмүүлэл хүнийг хааш нь хөтөлдөг вэ? сэдвээр лекц, сургалт орлоо. Та бүхэн [#MindUpdate](#) [#21aimag](#) [#JCI_ikh_khuree](#) [#Govisumber](#) хаш тагуудыг ашиглан өөрийн цахим хуудсанд эерэг пост оруулснаар аймагтаа хамгийн сүүлийн үеийн 2000 ширхэг ном хандивлахад дэмжлэг үзүүлэх тул хүүхэд залуучууд та бүхэн идэвхитэй оролцохыг уриалж байна.





Ан, амьтны хамгаалах ажлын хүрээнд:

Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулан дахь зэрлэг амьтдын өвс тэжээлийн хомсдлоос сэргийлэх хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум дундын Ойн анги, идэвхитэн байгаль хамгаалагч, малчидтай хамтран аргаль хонинд 6 байршилд 50 боодол өвс тавьж, биотехникийн арга хэмжээ зохион байгууллаа.



Аялал жуулчлал, тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Аймгийн Аялал жуулчлалын холботой уулзалт зохион байгуулж, 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан.

Байгаль орчны үнэлгээ, усны асуудлын хүрээнд:

Аж ахуйн нэгж байгууллагуудын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дүгнэж 17 аж ахуйн нэгж, байгууллагад Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар байгуулагдсан аж

ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2018 оноос хойш шинээр эвдрэлд орсон газруудыг бүртгэж газар зүйн мэдээллийг шинэчлэн Байгаль орчны мэдээллийн санд мэдээллийг бүрэн оруулсан.

Дотоод сургалт: Монгол улсын 2040 он хүртэлх “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг танилцуулах мэдээлэл, танилцуулгад 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр болж газрын дарга, мэргэжилтнүүд хамрагдлаа.



Тайлан нэгтгэсэн: Ахлах мэргэжилтэн

Б.Гандулам